

Бугат сумын Цэцэлэгт төлөвлөгөөт хяналт шалгалт
хийсэн тухай

Хяналт шалгалтын зорилго

Булган аймгийн засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2017 оны 10 сарын 09-ны өдрийн 01/19 дугаар удирдамжийн дагуу санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтыг хангуулах, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад оршино.

Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ц.Алтанхуяг
2017 оны 10 дугаар сарын 09-өөс ажлын 7 хоног

Шалгалтанд хамрагдсан байгууллага, объектын нэр

Бугат сумын Хусхан Цэцэрлэгийн 2015, 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

Шалгалтанд хамрагдсан объектын талаарх

товч мэдээлэл

Булган аймгийн Бугат сумын 3-р багт байршилтай Цэцэрлэг нь 5 ажиллагсадтай ба үүнээс Эрхлэгч багш 1, багш 1, туслах багш 2, тогооч 1 гэсэн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2015, 2016 онд 1-р гарын үсгийг эрхлэгч Д.Оюунтуяа, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Дагийсүрэн, С.Нямсүрэн нар зурж төрийн санд бүртгэлийн 040215201 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох "CTS" программаар бүртгэж хөтөлсөн байна.

Өмнөх шалгалтын талаар

Булган аймгийн Аудитын газраас тус газрын 2015, 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж дүгнэжээ.

**Шалгалтын явцад хийгдсэн ажил,
шийдвэрлэсэн асуудал**

Тус байгууллагын 2015, 2016 оны касс, харилцахын баримт, няравын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журнал, даргын тушаал, цалин олгох хүснэгт,

нийгмийн даатгалын болон татварын, санхүүгийн тайлан, 2015, 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын газрын дүгнэлт зэрэг баримт материалуудад тулгуурлан Эрхлэгч Д.Оюунтуяа, Нягтлан бодогч Б.Дагийсүрэн нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

Санхүүжилт, орлогын талаар:

2015 онд Сумын Цэцэрлэг төсвөөс 89949,8 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн ба 89949,8 мянган төгрөг авч үйл ажиллагааны зардалд 89949,8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2016 онд Сумын Цэцэрлэг төсвөөс 97763,4 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн ба 97763,4 мянган төгрөг авч үйл ажиллагааны зардалд 97763,4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангаар:

2015 оны Сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 21036,4 мянган төгрөг дээр 4116,0 мянган төгрөгний тоног төхөөрөмж, 1812,8 мянган төгрөгний тавилга хэрэгсэл, 15,0 мянган төгрөгний ном, 5990,0 мянган төгрөгний бусад үндсэн хөрөнгө нэмэгдэж, 2163,9 мянган төгрөгний тоног төхөөрөмж, 162,7 мянган төгрөгний тавилга хэрэгсэл хасагдаж жилийн эцэст 30643,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2016 оны Сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 30643,5 мянган төгрөг дээр 2099,8 мянган төгрөгний тоног төхөөрөмж, 2,8 мянган төгрөгний ном үндсэн хөрөнгө нэмэгдэж жилийн эцэст 32746,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2015 онд Сумын Цэцэрлэгийн бараа материалын эхний үлдэгдэл 24098,4 мянган төгрөг дээр 34,5 мянган төгрөгний эм боох материал, 5369,1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 1092,2 мянган төгрөгний шатах тослох материал, 15786,0 мянган төгрөгний хүнсний материал нэмэгдэж 45,3 мянган төгрөгний эм боох материал, 5438,2 мянган төгрөгний аж ахуйн материал, 972,2 мянган төгрөгний түлш шатах тослох материал, 16008,5 мянган төгрөгний хүнсний материал үйл ажиллагаандаа зарцуулж оны эцэст 23916,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

2016 онд Сумын Цэцэрлэгийн бараа материалын эхний үлдэгдэл 23916,0 мянган төгрөг дээр 31,5 мянган төгрөгний эм боох материал, 3610,6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 1504,8 мянган төгрөгний шатах тослох материал, 14375,3 мянган төгрөгний хүнсний материал нэмэгдэж 31,5 мянган төгрөгний эм боох материал, 1436,1 мянган төгрөгний аж ахуйн материал, 1457,8 мянган төгрөгний түлш шатах тослох материал, 14873,7 мянган төгрөгний хүнсний материал үйл ажиллагаандаа зарцуулж оны эцэст 25639,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Өглөг, авлагын талаар

2015 онд НДШ-д 28,9 мянган төгрөг, түлш халаалтад 33,0 мянган төгрөгний өглөгтэй, авлаггүй, 2016 онд өглөггүй, байгууллагаас 16,9 мянган төгрөгний авлагатай тайлан баланс гарсан байна.

Төсөвт зардлын талаар /мян.төг/

2015 онд Сумын Цэцэрлэг төсөвт зардлыг 89949,8 мянган төгрөгөөр төлөвлөсөн, гүйцэтгэлээр 89949,8 төгрөгийг зарцуулсан байна.

2015 онд Сумын Цэцэрлэг нийт төсвийн зардлын 55,5 хувь буюу 49947,3 мянган төгрөгийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардалд, 6,2 хувь буюу 5567,7 мянган төгрөгийг ЭМНДШимтгэлийн зардалд, 0,4 хувь буюу 338,7 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 0,5 хувь буюу 474,6 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардалд, 4,4 хувь буюу 3924,5 мянган төгрөгийг түлш халаалтын зардалд, 17,5 хувь буюу 15786,0 мянган төгрөгийг хоолны зардалд, 1,1 хувь буюу 1015,6 мянган төгрөгийг хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардалд, 4,4 хувь буюу 3995,5 мянган төгрөгийг үр дүнгийн урамшуулалын зардалд, 0,07 хувь буюу 69,2 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардалд тус тус зарцуулсан.

2016 онд Сумын Цэцэрлэг төсөвт зардлыг 97763,4 мянган төгрөгөөр төлөвлөсөн, гүйцэтгэлээр 97763,4 төгрөгийг зарцуулсан байна.

2016 онд Сумын Цэцэрлэг нийт төсвийн зардлын 51,7 хувь буюу 50588,1 мянган төгрөгийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардалд, 5,6 хувь буюу 5471,4 мянган төгрөгийг ЭМНДШимтгэлийн зардалд, 0,4 хувь буюу 409,1 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 0,9 хувь буюу 881,7 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардалд, 5,0 хувь буюу 4881,4 мянган төгрөгийг түлш халаалтын зардалд, 14,7 хувь буюу 14378,3 мянган төгрөгийг хоолны зардалд, 2,3 хувь буюу 2295,7 мянган төгрөгийг зөөлөн эдлэл нормын хувцас худалдан авах зардалд, 5,7 хувь буюу 5629,2 мянган төгрөгийг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардалд тус тус зарцуулсан.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шилэн дансны нэгдсэн сайтад Цэцэрлэг нь 2017 оны 01-09-р сарын төсвийн төлөвлөгөө гүйцэтгэлийг байршуулсан байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, шалтгаан

1. Жолоочийн тооцооны хуудсанд нягтлан бодогч тооцоо бодолт хийгээгүй явсан км, түлш зарцуулалтын норм, спидометрийн заалт зэргийг буруу бичсэн, зөрүүтэй, шатахууны тайланг авсан шатахуундаа тааруулан гаргадаг, агуулахын бүртгэл хөтлөөгүй, томилолтыг бодож гарын үсэг зурж баталгаажуулахгүйгээр мөнгийг олгосон байгаа зэрэг нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13,1-д / Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, мөн хуулийн 13.5-д /Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно./, 13.7-д /Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Цалингийн тооцооны хүснэгт болон гарт олгох хүснэгт дээр гарын үсэг зурж баталгаажуулдаггүй

3. Шалгалтаар тус байгууллагын Эрхлэгч Д.Оюунтуяа, нягтлан бодогч Б.Дагийсүрэн нар нь 2015 оны 03 сарын 27 нд шатахууны үнэ болох 39400 төгрөг, 2015 оны 03 сарын 30 нд 16600 төгрөгийг Орхон НИК ХХК-ны Хаан банк дахь 5090001954 тоот дансанд, 2015 оны 03 сарын 27 нд шатахууны үнэ болох 41000 төгрөг, 2015 оны 04 сарын 21 нд 108000 төгрөг, 2015 оны 05 сарын 25 нд 55400 төгрөгийг иргэн С.Цасанбаатарын ХААН банк дахь 5273058522 тоот дансанд, нийт

260400 төгрөг шилжүүлсэн боловч материалын орлого зарлагын тайлан, жолоочийн тооцооны хуудас байхгүй, ямар ажилд хэрэглэсэн нь тодорхойгүйгээр санхүүгийн тайланд зардал болгон тусгасан байгаа нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтуудыг зөрчсөн байна.

4. Цэцэрлэгийн эрхлэгчийн 2015 оны 12 сарын 17 ны 15 тоот тушаалаар 4-р улиралын үр дүнгийн урамшуулалыг багш Б.Мөнхтуяад 45%, туслах багш С.Одгэрэлд 40%, Ц.Батжаргалд 45%, тогооч Ш.Гэрэлмаад 45% иар бодож олгосон боловч 2015 оны 12 сарын 18 ны 16 тоот тушаалаар багш Б.Мөнхтуяад 100% буюу 550369 төгрөг, туслах багш С.Одгэрэлд 98% буюу 418813 төгрөг, Ц.Батжаргалд 99% буюу 464414 төгрөг, тогооч Ш.Гэрэлмаад 100% буюу 452155 төгрөг нийт 1885751 төгрөг илүү тооцож, үр дүнгийн урамшуулалыг давхардуулан олгосон байна.

5. Шилэн дансны нэгдсэн сайтад Цэцэрлэг нь 2017 оны 3-р улиралд 109 мэдээлэл байршуулахаас 108 мэдээлэл байршуулж 1 мэдээлэл огт мэдээллээгүй, 9 мэдээлэл хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-д /Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 сарын 25-ны өдрийн дотор, сар, улиралын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор/, мөн хуулийн 8.2-д /Төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ/ заасан заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**. Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа,
зөвлөгөө өгсөн байдал**

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар улсын байцаагчийн 1 актаар 260400 төгрөгийн төлбөр тогтоож, 1 албан шаардлага хүргүүлэв.

Зөрчил дутагдлыг арилгуулж, таслан зогсоох зорилгоор 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Дүгнэлт

Тус байгууллагад Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь заалтууд, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар”-ын хэрэгжилт хангалтгүй байна.

Анхан шатны баримтуудын гарын үсгийн бүрдэл дутуу, нярав шатахууны тайлан гаргаагүй, шатахууны тайланг нягтлан бодогч шалгаж хүлээн аваагүй, нярав нь агуулахын бүртгэлийг хүнснээс бусад материалд хөтлөөгүй, бодолт хийгээгүй томилолтоор томилолтын зардал олгосон байгаа нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт хийгдээгүй ажлын хариуцлага сул байгааг харуулж байна.

Цаашид авах арга хэмжээний санал

1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, улсын байцаагчийн актаар тогтоогдсон төлбөрийг хугацаанд нь барагдуулж, мэргэжил арга зүйн зөвөлгөөг биелүүлж ажиллах

2. Дотоодын хяналт шалгалтыг сайжруулж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

БИЧСЭН:

САНХҮҮ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ц.АЛТАНХУЯГ